

“Монгол-Германы хоорондох эдийн засаг, худалдааны харилцааны асуудлаар Москва дахь Элчин сайдын яамнаас төвтэйгээ болон төвийн албан байгууллагуудтай харилцаж байсан баримт материалууд”
(1928.11.10 - 1939.06.19.)

Цахилгаан гэрлийн хорооноо хэрэгсэх хэрэглэл зүйлүүдийг Москва зэрэг хотоор нэвтрүүлэн ирүүлэх зөвшөөрөл олгоно уу хэмээх хэргийн эх ¹

Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсаас Монгол Улсад суугаа Бүрэн Эрх Барих Элчин сайдын яаманд

Эдүгээ Аж ахуйн яамнаас,

Цахилгаан Чийдэнгийн Ерөнхий Хорооны цахилгаан техникт чухал хэрэглэгдэх зургаан зүйлийн хэрэгслийг Монголын цахилгаан гэрлийн хороогоор уламжилж Герман улсын Берлин хотноо бүхий мөн улсын пүүсээс худалдан авч энэ он 6-р сарын 15-ны дотор нааш ирүүлэхэд Москва хотоор дамжуулан ирүүлэх тухай виз лиценз хэмээх зөвшөөрлийн бичгийг мөнхүү Цахилгаан гэрлийн хорооны нэрээр олгуулна уу хэмээсэн үүнд, эл хэрэгслүүдийг цааш холбогдох улсын нутаг дундуур Москва, Үд хотуудаар шууд нэвтрүүлэн ирүүлэх явдлыг хоёр улсын гүн найрамдлын тусламжаар нэн даруйхан зөвшөөрлийг олгож хариу ирүүлэн гүйцэтгүүлнэ үү хэмээн уг зүйлийн нэрийг тодорхойлсон хуудсыг хавсарган хүргүүлэв.

Сайд Гүрсэд
Эрхэлсэн түшмэл Амгалан
Хэлтсийн эрхэлсэн түшмэл Чогдонжамба
Туслах түшмэл Ринчиндорж
1929.04.09.

№ 358

¹ Мөн гэнд, хуудасны дугаар 2.

**630 тоот хэргийг зохих газар явуулсныг
мэдэгдэх ба үүнээс урагш түүгээр худалдааны
төлөөлөгчтэй харилцана уу хэмээсэн бичгийн
эх¹**

Аж ахуйн яаманд

Таны 630 тоот бичгийг үзэж зохих явуулсан бөгөөд хариу ирэх тухайд жич мэдэгдэхээс гадна эл цахилгаан гэрлийн хэрэгслийг цаашид Герман улсаас ирүүлэх тухайд тус улсаас холбогдох улсад суугаа худалдааны төлөөлөгчид түүгээр явуулан хавсарган гүйцэтгүүлэх ба мөн үүнээс урагш энэ мэт явдлыг харьяат төлөөлөгчид нэгэн адил явуулан гүйцэтгэж байвал аливаад дөхөмтэй болох мэтийг хойш явуулсугай.

Сайд Гүрсэд
Эрхэлсэн түшмэл Амгалан
Хэлтсийн эрхэлсэн түшмэл Чогдонжамбаа
Туслах түшмэл Эрэнчиндорж

¹ Гадаад хэргийн яамны Тов архив. Фонд № 6, халгаламжийн нэгж № 6, хуудасны дугаар 3.

Нугалбар бичиг

1930.10.20.

Өрнөд хэлтэс № 511

Магадыг хянаж түүгээр гүйцэтгүүлнэ үү хэмээсэн тухай¹

Дотоодыг Хамгаалах Газар
Монгол-Трансын Ерөнхий Хорооноо

Эдүгээ хувь нийлүүлсэн Монгол-Трансын Ерөнхий Хорооноос тус улсад ирэх Мерседес-Бенз хэмээх машин тэргийг харьяат улсын орон нутгийн байдалд нийцэлдэх эсэхийг шинжлэн үзэх комисс байгуулахаар Алтанбулаг хотоор хязгаар нэвтрэн ирэх Герман улсын Мерседес-Бенз хэмээх машин тэрэг үйлдэх пүүсийн төлөөлөгч, мөн улсын харьяат Карл Швагерийн биед түр хугацааны үнэмлэх бичиг олгоно уу хэмээн 3648/3702 тоотуудаар удаа дараагаар шаардан ирүүлсэн үүнд байцаавал тэрхүү Карл Швагерийн биеийг тийнхүү дурьдсан ажлыг гүйцэтгэх түр хугацааны үнэмлэх олгож ирүүлэхэд манай яамнаас онц татгалзахгүй бөгөөд түүгээр магадыг хянаж гүйцэтгэх ажаамуу.

Үүнийг Монгол-Трансын Ерөнхий Хорооноо мэдэгдсүгэй.

Сайд Чойбалсан

¹ Мөн тэнд, уг нэгжийн 8-р хуудсанд 1931 оны 3-р сарын 12-ны өдөр “Монгол-Трансад урилгаар ажиллах Герман улсын харьяат Кречманыг Монгол Улсын хил гаалийг саадгүй нэвтрэх виз олгох явдлыг Алтанбулагын газар уламжлахыг хүсэж Монгол-Трансын Ерөнхий Хорооны дарга Аболов, Бичиг хэргийн эрхлэгч Кузнецов нараас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад явдлын яаманд явуулсан № 22 тоот албан бичиг байна. Гадаад Явдлын Яамнаас 1931 оны 9-р сарын 13 нд Герман инженер Кречманы хэргийг тасласан тухай бичиг гаргасан байна. Гэжээ энэ нь албан ёсоор тэмдэглэгдээгүй байна. Мөн түүнчлэн хэрэг тасласан гэдэг нь ямар агууллагатай болох нь тодорхойгүй. Миний бодоход зөвшөөрөл олгосныг хэлсэн болов уу. Харин 10-р хуудсанд 1930 оны 10-р сарын 16-ны өдөр Хувь Нийлүүлсэн Монгол-Трансын Ерөнхий Хорооны Г.Б.Шатовоос Герман улсын инженер Швагерийг хил нэвтрүүлэхийг хүссэн № 3709 тоот албан бичиг илгээсэн бөгөөд уг бичигт Алтанбулагын хязгаарыг нэвтрэх бичгийг олон өдөр гүйснаа мэдэгдсэн байдаг.

Монгол Улсын Хувь Нийлүүлсэн Зам Тээврийн Ерөнхий Хороо

Монгол-Транс
Улаанбаатар хот
1930.10.14.

Ерөнхий №710
Өрнөд хэлтэст

Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаа ¹

Эдүгээ тус улсад ирж "Мерседес-Бенз" хэмээх машин тэргийг тус улсын орон нутгийн байдалд нийцэлдэх эсэхийг шинжлэн үзэх комисс байгуулахаар энэ сарын арван таван буюу 17-ны өдөр Алтанбулаг хотоор хязгаар нэвтрэн ирэх Герман улсын "Мерседес-Бенз" хэмээх машин тэрэг үйлдэх пүүсийн төлөөлөгч, мөн улсын харьяа инженер Карл Швагерийн биед түр хугацааны пропуск олгохын эрж явуулав.

О.С. Абалов
С.А. Кузнецов

БНМАУ-ын Худалдаа ба Аж Үйлдвэрийн Яам

¹ Гадаад хэргийн яамны Тов архив. Фонд № 6. Хадгаламжийн нэгж № 6. Хуудасны дугаар 13.

1931.03.03.
Үнэмлэх олгосон тухай¹

1931. 08. 22².

Монгол Улсын Гадаад явдлын яамны сайд Чойбалсанд

Эрхэм сайд танаа

Герман улсын Засгийн Газар нь энэ оны 7-р сард баригдсан немец угсааны хоёр ард иргэн болох бөгөөд нисэх онгоцны жолооч Фридрих ба Кольбер хэмээгчүүдийг суллан тавих ба мөн түүнчлэн Герман улсын "Европ ба Ази" пүүсийн нисэх онгоцыг эргүүлэн өгөхийг гуйж буй хэмээн СССР улсын Гадаад Явдлын Ардын яамнаа мэдүүлж, улмаар Монгол Ард Улсын Засгийн газар уламжлахийг гуйсугай.

Дээр дурьдсаныг миний бие болбол Гадаад явдлын яамны эрхэм сайдаас хянан шийтгэх явдалд хүргэх сэтгэл бүхий амой.

СССР улсаас Монгол улсад суугаа Элчин сайд Охотин

№ 434
1931.11.28.

¹ Гадаад Хэргийн Яамны Төв Архив, Фонд № 6, Хадгаламжийн нэгж № 6, Хуудасны дугаар 21.

² Мөн тэнд, 24-р хуудас. Засгийн газрын 1931 оны 9-р сарын 4-ний өдөр хуралдсан ХҮИ хурлын тогтоолын 1 зүйлд герман нисэгчдийн хэргийг шийлсэн тухай заасан байдаг бөгөөд энэ асуудлаар Монгол улс дахь ЗОУ-ын Элчин сайд Охотинд мөн өдөр албан ёсоор мэдэгдсэн байна. Уг хадгаламжийн нэгжийн 27-28-р хуудсанд 1931 оны 8-р сарын 8-нд БНМАУ-ын Улсын Бага Хурлын төлөөлөгчдөөс өршөөл үзүүлэхийг гуйсан Иохан Ратъегийн өргөдөл хадгалагдаж байна. Уг өргөдөлд бичсэнээр 1931 оны 8-р сарын 6-ны өдөр тус улсын Дээд Шүүхийн Таслах Цэргийн Коллегийн тогтоолоор түүнд 5 жилийн хугацаагаар хорих ял шийтгэснийг дурьдан бичсэн байна.

Мөн хадгаламжийн нэгжийн 31-р хуудсанд 1931 оны 9-р сарын 27-ны өдөр Герман улсын хоёр нисэгчийг ялаас чөлөөлж нисэх онгоцны хамт буцаан явуулах асуудлыг Москва хот дахь Монгол улсын Элчин сайдаас шаардан хүсэж хариу ирүүлэхийг хүссэн № 377 тоот албан бичиг хадгалагдаж байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Зөвлөлийн Засагт Холбоот Улсад суугаа Бүрэн эрх барих Элчин сайдын яамнаа ¹

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаа

Саяхан Герман улсын Люфтганза хэмээх агаарын тэрэгний хувь нийлүүлсэн хоршооны төлөөлөгч Вольтер хэмээх хүн манай яамнаа ирж гуйн мэдүүлээд хүссэн нь, манай хоршооноо албан хааж байгаад танай Монгол улсын Засгийн газраас тусгай зөвшөөрөлгүйгээр мөн улсын зүүн урьдах хязгаарын дэвсгэр дээгүүр агаарын онгоцоор нисэж яваад баригдсан 2 жолооч нараас туйлын халуун баярыг бүрэн хүндэтгэн хүргэснийг уламжилъя хэмээхээс гадна манай Герман ба Хятад хоёр улсын хооронд байгуулсан агаарын онгоцны хоршоо эдүгээ Манжуур ба Шанхай хот хоёрын дунд ажиллаж буй бөгөөд "Люфтганза"-ийн Ерөнхий хорооноос туйлын гуйж хүсэх нь манай агаарын онгоцнуудыг Манжуур хотоос Шанхай хот хүртэл үргэлж явахад танай улсын зүүн урьд хязгаарын дэвсгэр дээгүүр дайран гарч байх зөвшөөрлийг эрхэм Монгол улсын Ардын Засгийн газраас олгохыг гуйсугай.

Хэрэв зөвшөөрлийг олох ахул тэрхүү агаарын тэргүүдэд бүхий л албан хаах этгээдүүд нарыг цөмөөр Герман улсын харьяат нараар гүйцэтгүүлнэ хэмээхээс гадна Монгол улсын нутгийн дэвсгэр дээгүүр нисэх бүхий л цаг үест цөм ямар ямар газраар нисэх ба түр буух зогсох өртөө буудал зэргийн зүйлүүдийг уг тогтоосон тушаал зааврын ёсоор нэг ч зөрчихгүйгээр эгнэгт гүйцэтгэж байхыг хамгийн чухал болгож тэмдэглэжээ.

Үүнд хянаваас туйлын чухал бөгөөд ноцтой сонирхолтой асуудал лав мөн болох тул, үүгээр холбогдох улсын Гадаад явдлын яамны нөхөдтэй нөхрийн хувиар харилцан ярилцсан бөгөөд зүй нь уул гуйсны ёсоор болгоход ихээхэн бэрхшээлтэй ба эцэст тун аюултай зүйл гарахуйяа болзошгүй ба нөгөөтэйгүүр манай улсаас хэрхэвч үүнийг зөвшөөрөхгүй байна хэмээн шууд харилцах хэмээвэл дэлхий дахины олон улсуудын хоорондын агаарын

1 Гадаад Хэргийн Яамны Төв Архив, Фонд № 6, Хадгаламжийн нэгж № 6, Хуудасны дугаар 32.

тэрэгний харилцаа байгуулах явдалд хараахан даруй нийлэмжтэй болсон хэмээхэд бас бэрхтэй тул арга буюу энэ асуудлыг хоёр улсын дунд урьдаар сайтар нарийн хянан хэлэлцэж тогтсоны дараагаар нарийн бодлоготой хариу ирүүлбэл болох болов уу хэмээн хэлэлцээд үүнийг тун яаравчлан эрхэм Гадаад явдлын яамнаа бүрэн хүндэтгэн явуулаад түүгээр нягтлан хэлэлцэж зохих хариу зааврыг нэн даруйхан ирүүлэх ажаамуу хэмээн үүний тул явуулав.

Элчин сайд

1931 оны 6-р сарын 10-ны өдрийн 2 цагт Монголын Элчин сайдын гэрт Герман улсын Элчин сайдын газрын атташе фон Гервад, орчуулагч Дамров нар явган явж ирэв.¹

Монголын Элчин сайдын яамны, Чимиддаваа эд нарыг хүлээн авч орчуулагчаар харилцан ярилцав.

фон Гервадаас:

Манай Герман улсын Элчин сайдын газраас үүний урьд танай Элчин сайдын яамнаа Герман улсын харьяат Берм Голстийн хувийн хөрөнгө болох 73 330 төгрөгийг эргүүлэн өгөх тухай танай яамны нарийн бичгийн дарга нар анхнаа ноён Хайсандай, Балжирун нарт бичиж гуйсан байна. Энэхүү Берм Голстийн бие 1929 ба 30 онд адуу худалдаалан явсан ба мөн өөрийн биеэр Монгол улсад одсон байна. Энэхүү дээр дурьдсан мөнгө Монгол банкны харилцах дансанд байсныг ийнхүү Монгол банкнаа саатуулсан байна. Сүүлчийн бичгийг 1930 оны 12-р сарын 17-ны өдөр бичсэн байна.

Үүнээс гадна Монголын сурагчдын тухай, мөн энэ сурагчдын хамт явсан Ишдорж ба Гомбожав нарын тухай сайн мэднэ. 1931 оны 9-р сарын 26-ны өдөр манай № 1305 тоотын дотор дурьдсан 1490 герман марк ба 1931 оны 7-р сарын 8-ны өдрийн 3447 герман маркийн тухай бичиг хүргүүлсэн байна.

¹ Гадаад хэргийн яамны Төв архив, Фонд № 6, Хадгаламжийн нэгж № 6, Хуудасны дугаар 35-37.

1931 онд нэгэн сайхан өдөр бид нар Монголын Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Балжирунтай уулзаж ярилцсан байна. Балжирунаас Монголын Засгийн газрын өмнөөс манай Герман улсын Элчин сайдын газарт монгол сурагчид энэ хэр механик, дархчууд болж ирсний төлөөнөө баярыг хүргэсэн байна.

Энэ нь хэдийгээр сайшаалтай хэрэг боловч мөнгөний тухай хариу нь эдүгээ хүртэл гэрээ төдий байна. Үүний зэрэгцээгээр манай улсын Гадаад яамнаас цаг иймд энэ мөнгөний тухай хариуг танай Элчин сайдын яамнаас хүсч байна.

Учир иймд бид нараас энэ дээр хэлэлцсэн зүйлүүдийн тухай хариу өгөхийг бас дахин хүснэ.

Чимид-Даваагаас:

Энэ тухайн хэрэг ба асуудлын тухайг би сая энэ өдөр мэдэж байна. Хайсандай ба Балжирун нар энэ хэр Москва хотноо үгүй. Мөн нутаг буцах тухайд энэ тухай надад хэлсэнгүй байна. Иймд би таны хэлснийг Элчин сайдад мэдэгдэж мөн Элчин сайдаас харьяат Засгийн газраас лавлаж мэднэ. Энэ таны гэрээний тухайн хариуг түргэн ирүүлэхийг бид нараас оролдох ба болбол энэ тухай мөнгийг эрхбиш олгох хэмээн батлан хэлж чадахгүй байна. Гэвч энэ хэргийг тодорхой мэдэж, Улаанбаатараас хариу ирмэгц танд хариуг даруй мэдэгдье!

Дамровоос:

Хичээнгүй ноён нарийн бичгийн дарга би таныг энэ хэргийн хариуг даруй авч өгөхийг гуйна. Бид нар танд аль ч нэгэн хариуг авч өгсөн их л баясана. Мөн манай Элчин сайдын газраас харьяат Гадаад яамдаа хариуг өгөх хэрэгтэй байгаа хэмээгээд Чимиддаваа хоёр хэсэг цаас өгсөн нь нэг нь Ишдорж, Гомбожав нарт илгээсэн ном, дэвтэрийн тухай 71 герман марк, нөгөө нь Герман улсын харьяат Антон Вехерийн тухай. Энэ Вехер болбол Улаанбаатар хотноо ажилласан гэрлийн ... хорооноос хийж байсан ба энэ хүн Улаанбаатар хотын цагдан сэргийлэх газраас үүний 100 тооны зургуудыг бичсэнийг Москва хотноо бүхий манай улсын Элчин сайдаас илгээнэ хэмээсэн боловч эдүгээ хүртэл ирүүлээгүй байна.

Мөн үүний хамтаар гуйх нь болбол энэ асуудлын тухай хариуг нэгэн хамтаар өгөхийг хүснэ.

Чимэддаваагаас:

Хариу очно хэмээн зөвшөөрч өгүүлсэн нь энэ удаа энэ тухай хариу Улаанбаатараас ирээгүй байна.

фон Гевардаас:

Дамров Монголын элчин сайдын гэрээс гарахын завсар манай утасны дугаар 18111 болохыг мэдэхийн хамтаар хэрвээ энэ тухай асуух хэрэг гарах ахул энэ дугаараар ярих, мөн ч манай Элчингийн газраас хүнийг ирүүлж болно. Дамров би танай элчингийнд ирэх тухай цаг ямагт бэлхэн байна.

Гадаад явдлын яаманд¹

Эдүгээ энэ сарын 10-ны өдөр Москва хотноо суугаа Герман улсын Элчин сайдын газраас тус яамны нарийн бичгийн даргатай уулзахаар зөвшөөрлийг авч ирсэн атташе хэмээх нэгдүгээр нарийн бичгийн дарга Гевард хэмээх хүн өөрийн хэлний орчуулагч хамтаар ирж тус яамны нарийн бичгийн нөхөр дарга Чимиддаваатай албан ёсоор тус яамны газар уулзаж, урьд 15 ба 20 дугаар онд өөрийн харьяат нэгэн хүний Шанхайд морь авахаар явж танай улсын банкны газар орхисон 73 330 төгрөг мөн танай газраас манай улсад сургуулилан суусан Ишдорж нарын сүйтгэлийн үнэ зэргийг нэхэмжилсэн ба харилцсан зэргийг адил үсгээр тодорхойлон хүргүүлэв. Улмаар Банкны ерөнхий хороо ба Ардыг гэгээрүүлэх яамуудтай харилцан хэрхэн гүйцэтгэхийн хариуг нэн даруй ирүүлэхийг гуйсугай.

Москва хот дахь Монголын Элчин сайд Самбуу Нарийн бичгийн дарга

¹ Гадаад хэргийн яамны Төв архив, Фонд № 6, Хадгаламжийн нэгж № 6. Хуудасны дугаар 38. Уг хадгаламжийн нэгжийн 39-40-р хуудсанд буй 1935 оны 3-р сарын 23-ны Элчин сайдын яамны албан бичигт дурьдсанаар Герман улсын харьяат Герман Кериг хэмээх хүн Алтанбулаг хотын улсын архины заводод техник ангийн эрхлэгчийн албан тушаалд 1930 оны 10-р сараас 1933 оны 5-р сар хүртэл ажиллаж байсан тухай дурджээ. Мөн 42-р хуудсанд 1935 оны 8-р сарын 1-ний өдөр Монгол банкнаас № 4732 тоот албан бичгээр Гадаад явдлын яамаар дамжуулан Москва дахь Монгол улсын Элчин сайдын яаманд мэдэгдсэнээр гуравдагч оронд валют гуйвуулах үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргасан тухай дурьдсан байна. Ингэснээр Герман улсын Монголд ажиллаж байсан иргэд банкинд хадгалуулж байсан мөнгөө авч чадахгүй хохирох явдал их гарч байсан тухай уг бичигт дурьдсан байдаг. Харин 50-р хуудсанд 1939 оны 5-р сарын 16-ны Москва дахь Монгол улсын Элчин сайдын яамны албан захидалд Германы элчин сайдын яамны Нарийн бичгийн дарга Миллер гэгч хүн Монгол улсын сүлд тугийг Германы шинжлэх ухааны толь бичигт /энциклопедия/ хэвлэх гэж байгааг мэдэгдээд онгийг лавлахаар ирсэн тухай бичсэн байна. Гэвч манай тал татгалзан уг хүнгэй уулзаагүй тухай өгүүлсэн. Дээрх хүн 1939 оны 6-р сарын 19, 9-р сарын 15-нд дахин ирснийг мөн харну оголгүй буцаажээ. Манай тал уг хүнгэй орчуулагчийг уулзуулж хэлсэн бүхнийг бичиж авахын даалгасан бөгөөд тухайн үед Гадаад явдлын яаманд тагнан турших зорилготой гэж мэдэгдэж байв.

Нугалбар 6.

Дотоод яамнаас тус яамнаа Орос улс ба Герман улстай эмнэлэгийн тухай сурагч ирүүлэх ба эм авчирах зэргээр харилцахыг бодолхийлэн буй хэрэг

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Дотоод явдлын яамны бичиг

Б.Н.М.А.У-ын Гадаад явдлын яамнаа илгээв.

Явуулах учир. Ерөнхий хэлтсийн өргөсөн нь,

Эдүгээ Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаас нэгэн мянган нэгэн зуун хорин найман тоот бичгийг манай хүлээн авч үзэв. Байцааваас,

Дотоод яамны харьяат Ардыг эрүүлийг хамгаалах ба Аптекийн зэрэг хоёр газарт хүний эмнэлэгийн хувиар Зөвлөлийн Засагт Холбоот Орос Улсаас эмч нар урин ирүүлж хэрэглэж буй бөгөөд дараа мөнхүү Холбоот улс ба Герман улсаас чадвартай эмч нарыг урин ирүүлэх ба эмнэлэгийн явдал эрдэм боловсролын тухай харилцаж, элдэв эм, бодис зүйлийг нааш цааш авч өгүүлэх зэргээр харилцахыг бодолхийлэн буй тул үүнийг,

Монгол Ард Улсын Гадаад хэргийн яамнаа явуулаад байцаан үзүүлнэ хэмээнэ хэмээн эржээ.

Үүний тул илгээв.

Монгол улсын 16-р он, 12-р сарын 23.

Дугаар № 1469.

Сайд Амар
Эрхэлсэн түшмэл Цэенпил.

Монгол-Германы хоорондын худалдааны асуудалтай холбогдох бичиг баримт (1925-1928)¹

Монгол Улсын 18-р он 11-р сарын 11.
Дугаар 1162.

Цахилгаан гэрлийн хорооноо хэрэгсэх цахилгаан машиныг Герман улсын А.Е.С-ийн хоршооноос хязгаар нэвтрүүлэн ирүүлэх хэмээсэн

Монгол Элчин сайдын
Орос Элчин сайдын яамнаа
Өрнөд хэлтэс 192.

Эдүгээ Аж ахуйн яамнаас, Цахилгаан гэрлийн хорооноо уурын цахилгаан машины хэрэгсэл зэргийг Герман улсын А.Е.С-ийн хоршооноос худалдан авахаар хэлэлцэн гэрээ тогтоосон зүйл буй учир уг машин зэргийг СССР улсын хязгаараар дамжуулан тус улсын хязгаарт нэвтрүүлэх зөвшөөрөл олгуулна хэмээн 1878 тоотой нэвтрүүлэх зүйлийн нэрийн хуудсыг хүргүүлэн ирснийг манай яамнаас хязгаар нэвтрүүлэх зөвшөөрөл олгуулахаар СССР улсаас тус улсад суугаа Элчин сайдын яамнаа үүгээр өөрөө явуулсан тул мөнхүү машин зүйлийг хязгаар нэвтрүүлэн ирүүлэх явдлыг түүгээр нэгэн адил зохих газраас зөвшөөрөл авах зэргээр гүйцэтгэх дор бэлхэнийг тодорхойлсон герман үсгийн хуудас хүргүүлэв, хүлээн авч гүйцэтгэн хариу ирүүлэх ажаамуу.

Уг хуудасны хуулбар.

Эрхэм яамнаа хүргүүлэн явуулаад олдвол байцаан үзэж эл машин зүйлийг тооны ёсоор хязгаарыг нэвтрүүлэх зөвшөөрлийг зохих тусламжийн хамтаар олгуулах тухай залгамжлан зохих газар явуулан нэн даруй хойш хариу ирүүлэх ажаамуу.

Сайд
Орлогч сайд Буянчуулган
Эрхэлсэн түшмэл орлосон Амгалан

¹ Монгол Улсын 1-адаад хэргийн яамны Төв архив, Фонд №6. Монгол-Германы харилцааны данс 1-2, хуудасны дугаар 6.

Хэлтсийн эрхэлсэн түшмэл
Туслах түшмэл Дугаржав

Өрнөд хэлтэс 223.
18-р он 12-р сарын 15-наа
Дугаар 1534.

***БНМАУ-д ирсэн, буцсан герман иргэдийн Монголд
оршин суух, хил нэвтрэх, гарахтай холбогдсон
бичиг баримтын тухай
(1923-1927) ¹***

Нугалбар 1.

Герман улсаас Дундад улсад суугаа Элчин сайдын зөвлөх түшмэл албаны хэргээр Хүрээнээ ирээд хойш буцахад авч яваа зүйлийг аливаа зам тохиолдох тус улсын гаалийн хорооны газрын түшмэл, цэрэг албаны хүн задлан үзэхгүй өнгөрүүлтүгэй хэмээн олгох үнэмлэх бичгийн эх

Монгол Улсын Ардын Засгийн газрын Гадаад явдлын яамнаас, үнэмлэх, тамга дарсан бичиг шийтгэн олгосны учир,

Эдүгээ Герман улсаас Дундад Улсад суугаа Элчин сайдын зөвлөх түшмэл, Кибороос, миний бие мөнөөхөн албан хэргийн учир Нийслэл Хүрээнээ хүрч ирсэн, одоо хойш буцах тул авч яваа эл зүйлсийг Монгол хязгаарын дотор тохиолдох олон гаалийн хорооны газраа задлан үзүүлэхгүй өнгөрүүлэх үнэмлэх бичиг олгоно уу хэмээснийг манай яамнаас ёсоор болгосны тулд, аливаа зам тохиолдох тус улсын гаалийн хорооны зэрэг газрын түшмэл, цэрэг албаны хүмүүс саатуулан боогдуулахгүй найртай сайны ёсоор хамгаалан өнгөрүүлэх хэмээн үүний тул, үнэмлэх тэмдэг дарсан бичиг шийтгэн олгов.

¹ Монгол Улсын Гадаад хэргийн яамны Төв архив, Фонд №6, Монгол-Германы харилцааны ланс 1-2.

Герман улсын Юэн фунг Трединг пүүс (1922-1925) ¹

Герман улсын Юэн фунг Трединг хэмээх пүүсээс Монгол газраас морь хиу худалдан авч тус улсад нэвтрүүлэн явуулбал танай Засгийн газраас татгалзах эсэхийг хариу ирүүлнэ хэмээн 1922 оны 4-р сарын 19-ний өдөр № 236 тоотоор ирсэн бичиг

Юэн фунг Трединг хэмээх пүүсээс,

Манай улсын хувьсгалт Засгийн газрын Гадаад Монгол ардын хувьсгалт хэргийн яамнаа өргөв.

Мэдүүлэх учир,

Германы Консулын яамнаас манай пүүсэнд найрамдлыг илэрхийлэн Монгол улстай харилцан худалдаа нэвтрүүлсүгэй хэмээн тушаасныг дагаж Нийслэл Хүрээний газар манай пүүсээс салбар хороо байгуулж худалдаалж буй, уг нутгаас манай Консулын яаманд уналга морь дутагдан гаднаас худалдан авах болсны дээр Монгол газраас морь хиу худалдан авах манай улсад нэвтрүүлэн явуулахад танай Засгийн газраас татгалзах эсэх явдлыг хариу мэдэгдэх ажаамуу.

¹ Мөн тэнд, 4-р хуудсанд өгүүлснээс үзвэл Юэн фунг Трединг пүүс нь манай улсаас өөрийн оронд усан замаар агт морьд гаргадаг байсан бөгөөд Герман улсын Засгийн газартай холбоотой ажилладаг томоохон пүүс байсан бололтой.

Герман, Францад суралцахаар явсан монгол оюутнуудтай холбогдох бичиг баримтууд (1925-1926)¹

Нугалбар 7.

Ардыг гэгээрүүлэх яамны сургуулийн хэлтсээс, Герман зэрэг гадаадын улсад сургуульд одох хүүхдүүдээс хасагдсаны ор ба нэмэн явуулах хүүхдүүдэд паспорт олгоно уу хэмээн ирсэн хэрэг

Ардыг гэгээрүүлэх яамны сургуулийн хэлтсээс Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаа илгээв, хуудсаар явуулах учир, эдүгээ Герман зэрэг гадаад улсын сургуульд одуулах гучин хөвгүүнээс хасагдаж ор ба нэмэн явуулах хөвгүүдэд паспорт бичиг олговол зохихийн тулд биеийн зургууд ба нэр, нас зэргийг жагсаан бичиж хүргүүлсэн үүнийг эрхэм яамнаа явуулаад байцаан үзэж нэмэгдсэн зургаан хөвгүүд тус бүрт таваад жилийн хамгаалах паспорт бичиг, зургаан хувийг шийтгэн ирүүлэх ажаамуу, үүний тул илгээв.

16-р он 4-р сарын 22.

№ 604.

(Хуудасны ард дээрхи зургаан сурагчдын овог, нэр, төрсөн газрыг тодорхойлон бичсэн байна.)

Цэрэн Баатарсэнгэ, 18 нас, Хан Хэнтий аймгийн Улз голын хошуу

Хэпил Цэвээн, 14 нас, Богд хан уулын аймаг, Хутаг-Өндөр уулын хошуу

Ишгэн Содном, 17 нас, Цэцэрлэг мандалын аймаг, Эрдэнэбулган уулын хошуу

Самдан Лувсандамдин, 17 нас, Богд хан уулын аймаг, Хутаг-Өндөр уулын хошуу

Дугаржав, 20 нас, Дэлгэр Их уулын аймаг, Баянзүрх уулын хошуу

¹ Монгол Улсын Гадаад хэргийн яамны Гөв архив, Фонд №6, Монгол-Германы харилцааны данс 1-2.

Жич: Дээд Үд хотноо Багшийн сургуульд буй Аюурзана.

Дамбий бичээд Дугаржав хянав.

Нугалбар 8.

Москва

Монголын Элчин сайдад

Таван хүнийг Японд, гурван хүнийг Германд сургуулинаа явуулахаар байна. Эдгээрт зохих тусламж хамгаалалыг үзүүлнэ үү.

Ардыг гэгээрүүлэх яам

№ 330.

1926 оны 9 сарын 8-ны өдөр

(Цахилгаан утасны эх)

Нугалбар 10.

Монгол Ард Улсын Ардыг гэгээрүүлэх яамны сургуулийн хэлтсээс, Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаа илгээв.

Явуулах учир, эдүгээ манай яамнаас Герман улсын Берлин хотноо хэл, бичгийн сургуульд Пунцаг, Лувсанчүлтэм, Нацагдорж, Пагамдулам, Санжаа нарыг томилон явуулахаар тогтож үнэмлэх бичиг шийтгэн олгосны тул эд нарын биеийн зураг тус бүр хошуудыг хүргүүлсэн үүнийг, Гадаад явдлын яамнаа явуулаад байцаан үзэж биеийн хамгаалах бичиг таван хувийг шийтгэн ирүүлж ажаамуу.

Үүний тул илгээв.

1926 оны 9-р сарын 23-ны өдөр

№157.

Нугалбар 16.

Монгол Ард Улсын Ардыг гэгээрүүлэх яамны Сургуулийн хэлтсээс, Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаа илгээв.

Хуудсаар явуулах учир, эдүгээ манай яамнаас Базар Ишдоржийг Герман, Францын сургуульд буй монгол сурагчдын даргад томилон явуулах учир мөнхүү Базар Ишдорж, гэргий Цэрэндулам, хөвгүүн Санчир нарын гурван хүнд паспорт бичиг шийтгэн олгож явуулбал зохихийн тулд тэд нарын биеийн зураг гуравт хуудас дагалдуулан үүнийг, Гадаад явдлын яамнаа явуулаад байцаан үзэж, паспорт бичиг шийтгэн олгох ажаамуу хэмээн үүний тул илгээв.

16-р он, 12-р сарын 11.
Дугаар 222.

Нугалбар 18.

Илгээв.
Явуулах учир,
Өмнөд хэлтсийн өргөсөн нь,

Эдүгээ тус улсаас СССР улсад суугаа Элчин сайдын яамнаас Гадаад, Ардыг гэгээрүүлэх бидний хоёр яамнаа нэгэн адил илгээсэн № 234 тоот хуудас бичгийн дотор Герман ба Франциус улсад суугаа монгол сурагч нарын дарга Ишдоржийг Герман улсын Гадаад яамнаас урин аваачиж хэдэн зүйлийн хэргийг асуусан бөгөөд энэ учир даруйнаа Ишдоржоос захидал бичгээр тодорхойлон манай яамнаа мэдэгдэн ирсэн болно. Уг захидал бичгийн хуулбар нэгийг хүргүүлэн байцаан толилсугай хэмээн хуудас иржээ.

Доржпалам

1927 оны 12 сарын 3 –ны өдөр.

Нугалбар 21.

1928 оны 1 сарын 26-ны өдөр.

Эрхэм нөхөр Ишдорж танаа амрыг эрнэ.

Жич, сая нөхрөөс эрдэмтэн Хэнишийн тухай захидлаар мэдэгдэн ирсэн нь хэрд уламжлан зохих газраас цахилгаан мэдээгээр лавлан явуулаад, эдүгээ хойш мэдэгдэн ирсэн цахилгаан мэдээнд энэхүү эрдэмтэн нь манай Судар бичгийн хүрээлэнгээс ирүүлэхийг хүсэн хүлээсэн бөгөөд үүнд зам явах визийг хэрд олгуулж нэвтрүүлсүгэй үүрэг ирсэн үүнд хянаваас, эрдэмтэн Хэнишийг урьд сайд Батхаан, Жамсрановт илгээсэн захидал газар алсласан хол учир, харилцаанд үл нэвтэрч тийнхүү завсар саатсан улмаас хариу нь удсан болох болов уу хэмээхийн тул үүнийг, эрхэм нөхөрт мэдэгдээд хүсэх нь тэрхүү эрдэмтэнтэй түүгээр учирч эл тухай учир явдлыг сонсгон нэгэнтэйгүүр чухам хэдийд манай нутагт нэвтрэн ирэхийг лавлан асууж зам явах виз ба үнэмлэх бичгийг манай яамнаас гүйцэтгүүлж тус болохыг найртай сайн нь илэрхийлэн мэдэгдэнэ үү. Хэрэв түүний бие Москва хотоор дайран эс явах аваас чухам хэзээ аль газар хичнээн хоногийн хугацаагаар одох зэргийг тодорхойлон уг паспортыг зураг хоёрын хамт манай яамнаа ирүүлж гүйцэтгүүлэхийг хамтаар гарган үүний тул, амрыг эрж захидал бариулав.

Буянчуулган ёслов.

1-р сарын 26-ны найртай сайн өдөр.

1928 оны 2-р сарын 16.

Эрхлэгч Ишдоржид албан захидал дагалдуулан явуулахын илтаар амар эрж мэдэгдэх нь танаас албан бичиг дагалдуулан ирсэн эрдэмтэн Хэнишийн паспортод манай яамнаас виз дарах ба бас хязгаар нэвтрэхэд нэгжин үзэхгүйгээр нэвтрүүлэх үнэмлэх бичиг зэргийг гүйцэтгэн олгож захидлын хамтаар дугтуйд агуулж явуулсан нь хүрсэн дээр зохих этгээдэд олгох ажаамуу хэмээх илтаар амарыг эрж албан захидал бариулав.

Гомбо ёслов.

2 сарын 17-ны сайн өдөр.

Нугалбар 37.

Ардыг гэгээрүүлэх яамнаас сайд Батхаанд хичээлийн хэрэглэлийн мөнгийг банкаар гуйвуулсан учир хүлээн авсан эсэхийг зохих газар явуулсныг мэдэгдэн ирсэн бичиг

1926 оны 9-р сарын 7.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардыг гэгээрүүлэх яамны бичиг

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад хэргийн яамнаа илгээв.

Явуулах учир,

Ерөнхий хэлтсийн өргөсөн нь, саяхан манай яамнаас Герман улсад бүхий сургуулийн хүүхдүүдийн хэрэгсэл мөнгийг удаа дараа гуйвуулсан боловч завсарт хэрхэн удаашран саатсан учир тодорхойлон уг мөнгийг Берлин хотноо одсон сайд Батхаанд урьд одоогийн явуулсан ёсоор даруйхан гүйцэтгэн хариу ирүүлэхээр 206 тоот хуудсаар 8-р сарын 13-ны өдөр Банкны Ерөнхий Хорооноо яаран явуулаад Засгийн газраа, Гадаад яам, Намын Төв Хорооноо мэдэгдэн явуулсан нь эдүгээ мөн сарын 26-ны өдөр Банкны Ерөнхий Хорооноос манай банкнаас тухайд Харбины Даль банкнаас асуулт бичиг явуулсны хариуд тэдний банкнаас мэдэгдэн ирсэн нь уг гуйсны ёсоор энэ он 7-р сарын 14-ний өдөр гүйцэтгэсэн хэмээжээ хэмээн № 12999 тоот хуудас хүргэн ирснээр манай яамнаас энэ 8-р сарын 28-нд эл учир, Монгол Элчин сайдад утсаар мэдэгдсэн бөгөөд банкинд шаардан явуулсан учир тодорхой хуудас бичгийн хуулбар нэгийг хүргүүлэн үүнийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Зөвлөлийн Засагт Холбоот Улсын Москва хотноо суугаа Элчин сайдын яамнаа явуулаад энэ зүйлүүд мөнөөхөн бүрнээ сайд Батхаанд хүрч гүйцсэн эсэхийг түүгээр хянан шийтгэж хариу ирүүлэх ажаамуу. Ийнхүү учир нэгэнтэйгүүр Монгол Ард Улсын Засгийн газар, Гадаад явдлын яам, Монгол Ардын Намын Төв Хорооноо, Монголын Аж үйлдвэрийн Банкны Ерөнхий Хорооноо мэдэгдэн явуулаад байцаан үзүүлсүгэй хэмээнэ хэмээн өргөжээ.

Үүний тул илгээв.

Монгол улсын 16-р он, 9-р сарын 6.
Дугаар № 318.

Хамаарсан сайд Ишдорж
Эрхэлсэн түшмэл Лувсан

Нугалбар 38.

Монгол улсын 15-р он 7-р сарын 24.
Гадаад явдлын яамны Умард хэлтэс.
№ 459.

Ардыг гэгээрүүлэх яамнаас сургуульд үзүүлэх элдэв бодис, шинжлэх хэрэглэл зэрэг юм хаана буй нь мэдэгдэхгүй ба бас ч түргэн нааш нэвтрүүлэх явдлыг зохих газар явуулна уу хэмээн ирсэн хуудас.

Монгол Ард Улсын Ардыг гэгээрүүлэх яамнаас Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаа илгээв.

Хуудас явуулах учир,

Сургуулийн хэлтсийн өргөсөн нь, мөнөөхөн манай яамнаас Германы олон пүүсээс шууд ба Холбоот улсын Худалдааны төлөөний газраар уламжлан авсан сургуульд үзүүлэх элдэв бодисыг шинжлэх хэрэгсэл зэргийг Ленинград, Владивосток хоёр хотоор дамжуулан явуулсан. Мөн Холбоот улсын Транспорт хэмээх тээх нэвтрүүлэх хорооноос эрхлэн улмаар нааш эрхлэх хэмээсэн боловч тэрхүү ном хаана буух мэдэгдэхгүй тул одоо зүй нь эрхэмийн газраас тэрхүү номыг түргэн нааш нэвтрүүлэх ирүүлэх явдлыг зохих газар тушааж бас ч хаа явж буйг манай газар мэдэгдэж тусламж үзүүлнэ үү хэмээхээс гадна, энэхүү авсан зүйлийг Холбоот улсын Гадаадтай худалдаалах хэргийг эрхэлсэн яамнаас № 3853 тоот бичгээр гааль нэвтрүүлсэн бөгөөд чухам хичнээн хайрцаг байгаа, ямар нэр дугаартай юмыг нарийвчлан мэдэх хэрэгтэй хэмээвэл манай яамнаас тухайд тодорхойлон өгч болох учир хамтаар мэдэгдэн үүнийг Монгол Ард Улсын Гадаад явдлын яамнаа явуулаад, уламжлан зохих газраа явуулах ажаамуу хэмээн өргөжээ.

Үүний тул илгээв.

Эрхэлсэн түшмэл төлөөнөө Лувсан

Нугалбар 40.

Москва хотноо буй Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бүрэн эрх барих Элчин сайд ба харьяат яамны эрхэм түшмэд нарыг амрыг эрнэ. Эрхэм сайдаас ирсэн захидлыг хүлээн авч гүнээ баясав. Энэ завсар сонин болгон бичих юмгүй. Бид нар Герман улсын Гадаад яамны түшмэд нартай учирч манай Монголын дотоод, гадаадын байдал төлөвийг илтгэн тодорхойлсонд тэд нарын хэлсэн нь, Герман улс болбол дипломатын ба улс төрийн политикийн ёсоор Монгол улсыг сонирхон үзэх ба түүний тухай хэлэлцээ хэлэлцье үл чадах боловч эрдэм соёлын ёсоор монгол ард түмний байдлыг мэдэн авч, аливаа боловсронгуй эрдмийн тусламж хүргэхийг хүсэж байна хэмээснээс гадна август сарын гучидаар Засгийн газраас нэгэн эрдэмт түшмэлийг томилон Монголд явуулахаар завдан буй хэмээсэн, тэрхүү эрдэмт түшмэл болбол Берлин хотын Дээд университетийн сургуулийн багш бөгөөд 1923 онд Киргиз республикад одож тус республикийн харьяат киргиз ард түмний өвчин эрүүлийг шинжин үзэж ирээд тусгай дэвтэр герман хэлэн дээр хэвлэн гаргасан хүн болох болно.

Одоо түүний Монголд одох хэрэг нь, Нийслэл хүрээ, Улиастай, Ховд зэрэг газраар явж монгол ард түмний эрүүлийн байдлыг шинжин үзэж ямар тусламж үзүүлбэл зохихийг харьяат Засгийн газарт өргөн мэдүүлж, дараа Монгол улсын хязгаарт олон зүйлийн эм үйлдэх ба өвчний нь янз шалтгаан нь цаг үргэлжид шинжиж байх лаборатор нэгийг Монгол улсын Засгийн газартай хэлэлцэн хоёр этгээдийн сүйтгэлээр байгуулахыг хүсэх төлөвтэй буй.

Энэ мэт лабораторийг Кавказ уулын чанад дахь Тблиц хот ба бас Туркестанд байгуулсан хэмээнэ. Тэрхүү профессорын нэр нь Кюзенсис хэмээх дагах нөхөр нь Монгол газар хэдэн удаа явсан ба эрхэм нөхрийн таних Баурик хэмээх хүн буй учир үүнийг эрхэм нөхөд байцаан үзэж, олдвол Засгийн газар ба Алтанбулагын сайдад даруйхнаа уламжлан мэдүүлж, зохих тусламжийг түүгээр гүйцэд гаргуулах ажаамуу хэмээхээс гадна, тэдэнд төлбөргүй албан визийг олговол хэрхэх зохихийг эрхэм нөхөд түүгээр

хэлэлцэн гүйцэтгэх буй за. Бас тэр хоёр хүн нарыг яамандаа урьж цайлах танилцвал сайн буй.

Манай Засгийн газраас тэд нарт олговол зохих тусламж нь зам явахад хэрэглэх нэгэн орос, монгол хэлтэй орчуулагч хүн ба бас үнэ хялбартай, автомобиль буй үүн тухай урьдаар Засгийн газраа мэдэгдэнэ үү. Бас тэд нарыг Ринчинов ба Жамсранов хоёр хэрэв Москва хотноо ирсэн аваас танилцуулбал их л сайн буй.

Сампилон хичээнгүйлэн ёслов.
1925 оны 7-р сарын 19.